



**НИЙСЛЭЛИЙН
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2018 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 01/19

Улаанбаатар хот

**Хөдөлмөрийн аюулгүй байдал,
эрүүл ахуйн зөвлөлийг байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 126 тоот тушаал, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо шаардлага /MNS OHSAS 18001:2012/ стандартыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хөдөлмөрийн болон ажлын зохистой орчин, нөхцөлийг сайжруулах, осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, ХЭМАБ-ын /MNS OHSAS 18001:2012/ стандартын асуудлаар ажилтанууд хэлэлцэх, оролцох боломжийг хангах зорилгоор хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Б.Доржбалжир /ХАБЭА хариуцсан ажилтан/
Нарийн бичиг:	Н.Энхзаяа /Их эмч/
Гишүүд:	Ч.Шинэчимэг /Дотоод хяналт хариуцсан ажилтан/ Х.Цогзолмаа /Ерөнхий нягтлан бодогч/ М.Мөнхсүрэн /БАА-ны дарга/ Л.Уранхайч /Үйлчилгээний албаны дарга/ Г.Энхтуяа /Хүний нөөцийн менежер/ Э.Гал-эрдэнэ /Ерөнхий тогооч/

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг мөрдөж ажиллахыг зөвлөлийн дарга /Б.Доржбалжирт/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:



Х.ЭРДЭНЭБИЛЭГ

1150570037